

Зүүнхараа ОНХ-ийн 2022 онд Хүүхэд хамгаалал оролцоо, Өрхийн амжиргааг дэмжих, Орон нутгийн оролцоо ба хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрүүдээр дамжуулан Мандал, Сайхан, Баянгол сумдад хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан

2022.07.06

Хүүхэд хамгаалал оролцоо төсөл нь Зорилтот 3 сумандаа эцэг эхчүүдийн мэдлэг хандлагыг өөрчлөх, өсвөр насныхний бусдыг болон өөрийгөө хамгаалж чаддаг нэгэн болгон төлөвшүүлэх, хүүхэд хамгааллын механизмыг сайжруулах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тайлант хугацаанд:

1. Хүмүүжлийн эерэг арга сургалтын сургагч багшаар үндэсний хэмжээнд Мандал сумын 4р сургуулийн 2 багш, Хүүхдийн ордонь сэтгэл зүйч болон эрхзүйч нарыг сургаж орон нутагт уг аргачлалыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор бэлтгэсэн нь үр дүнтэй ажил болсон. Уг багш нар нийт 287 эцэг эх, 167 багш нарт сургалтаа зохион байгуулсан. Сургалтаар хүүхдийн эрх, хүүхдийг хүчирхийллээс хамгаалах арга замд суралцсан ба хүүхэдтэй ажиллах, хандлагаа өөрчлөхөд эцэг эхчүүдийг дэмжих, хүмүүжлийн эерэг аргын талаарх цогц мэдлэгийг эзэмшсэн. Цаашид орон нутагт сургагдсан багш нар маань тасралтгүй энэ чиглэлийн мэдээллийг түгээх бүрэн боломжтой болсон.
2. Гэр бүлийн уур амьсгалыг дэмжих тэдэнд урам зориг өгөх зорилготой зохион байгуулдаг Гэр бүлийн баяр хөөр сургалтыг сургагч багш нараар дамжуулан 97 зорилтот бүлгийн эцэг эхчүүдэд хүргэсэн. Сургалтын үр дүнд эцэг эхчүүд гэр бүлээ барьж босгох, дэмжих, хамгаалах, хайрын орчин бүрдүүлэхэд тусгай энгийн аргуудыг мэдэж бусдаасаа суралцаж чаддаг. Уг сургалтыг зохион байгуулах орон нутгийн сургагч багш нар хэдийнээ бэлтгэгдэн Дэлхийн зөн байгууллагын оролцоогүйгээр сургалтаа зохион байгуулж чадахуйц чадваржсан.
3. Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө аргачлалыг 2022 онд Мандал сумын ЕБ_ын 2р сургууль дээр хэрэгжүүлсэн. Уг ажлын хүрээнд 3 шатны хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 250 эцэг эх, 250 сурагч, 46 багш ажилтнууд оролцож сургууль дээрх тулгамдсан асуудлуудыг дэвшүүлж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх санал санаачлагуудыг боловсруулж сум орон нутгийн удирдлагуудад танилцуулахад бэлэн болсон. Өмнөх жилүүдэд Сайхан болон Баянгол сумын сургуулиудад хэрэгжсэн. Мандал 4р сургууль үлгэр жишээ авахуйц бусдад заах бүрэн боломжтой жишиг хэрэгжүүлж чадавхжсан.
4. Мандал болон Баянгол сумдын хамтарсан багийг чадавхижуулах зорилгоор багийн түвшинд ажилладаг 10 багийг тус бүр 4 цаг ажлын байранд зөвлөн туслах үйлчилгээг МАХХНС төвүүдийн нэгдсэн холбооний тэрүүн Ундраа багштай хамтран зохион байгуулсан. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд хамтарсан багийн гишүүд чадавхижиж багийн түвшинд кейс илрүүлэлт, хүчирхийллийг таньж мэдэх, урьдчилан сэргийлэх тал дээр илүү суралцсан. Мөн хамтарсан багаас ирүүлсэн кейст хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор 5 өрхөд хүнсний тусламж, 4 өрхийн хүүхдэд хувцасны шууд тусламжийг үзүүлсэн.

5. *Орон нутгийн хүүхэд хамгааллын чадавхийг нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Мандал, Саайхан, Баянгол сумдад багийн дэргэдэх эцэг эхийн зөвлөл бий болгох санаачлагыг дэвшүүлж сургалт зохион байгуулсан. Үүнд нийт 100 орон нутгийн төлөөлөл, удирдлагууд хамрагдсан. Ингэснээр хүүхэд, насанд хүрэгчдийг хамгаалж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хэрэг зөрчлийн шинжтэй үйлдлийг нээн илрүүлэх, арилгах, холбон зуучлах зэрэг олон талын ач холбогдол бүхий ажлын эхлэлийг тавьж өгсөн үр дүнтэй сургалт болсон.*
6. *Хүүхэд хамгаалалд хүн бүрийн оролцоо чухал сэдвээр Мандал сумын Түнхэл болон Хэрх тосгоны ЕБ-ын сургуулийн 85 багш ажилтнуудад сургалтыг мөн Ундраа багштай хамтран зохион байгуулсан. Сургалтаар нийгмийн ажлын олон талт үйлчилгээг хүргэх, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг илрүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай үндсэн ойлголт өгөх, мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэн ажилласан.*
7. *Хүүхдүүдийн дуу хоолойг сонсох, дэмжих чиглэлээр тэднийг бие даах, амьдрах ухаанд суралцуулах зорилготой Оролцоод хөгжье клубын сургалт, хөтөлбөр зорилтот 3 сумын 8 ЕБ сургуулиуд дээр хэрэгждэг ба тус клубуудыг чиглүүлэгч багш нарын туршлага солилцох, бие биенээсээ суралцах боломжийг хангах зорилгоор 25 чиглүүлэгч багшийн эргэн дүгнэр уулзалтыг зохион байгуулсан. Мөн тэдний идэвхи оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр оролцооны клубуудын үйл ажиллагааг дэмжих идэвхижүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн ГБХЗХГ_тай хамтран Хамтдаа суралцая, хөгжье, хамгаалая уриан дор төслийн уралдаан зохион байгуулсан. Уг уралдаанд Мандал 1р сургуулийн хамтлаг төсөл, Түнхэл ЕБС-н үе тэнгийнхний дээрэлхэлтийг бууруулах төсөл, Сайхан 1р сургуулийн Титэм клубын Оролцоод хөгжье төсөл, Мандал 4р сургуулийн Ангилбал алт, хаявал хог төсөл, Номгон ЕБС оролцоод хөгжье клубын төсөл, Баянгол сумын оролцоод хөгжье клубын төслүүд шалгарч сургалтын хэрэглэгдэхүүний бараа материалуудаар дэмжигдсэн.*
8. *Аймаг сумын хэмжээнд хүүхдийн дуу хоолойг сонсох өдөрлөгийг зохион байгуулсан ба тэдгээр санал санаалчлагуудаас Мандал сумын 2р сургуулийн хүүхэд хөгжүүлэх амьдрах ухаанд сургах технологийн өрөөний тохижилтод 5 ширхэг токарын машин авах төсөл, Хэрх тосгоны ЕБС_ийн гадаа нэгдсэн хогийн савгүйгээс ил задгай хог хаягдал үүсч байгаатай холбоотой хогийн савны төсөл тус тус шалгарч шийдвэрлэгдэж байна.*
9. *Зорилтот 3 сумын ЕБ_ын сургуулиудын нийгмийн ажилтнууд болон сэтгэл зүйчдийг гэрээр айлчлах аргачлалд сургаж чадавхижуулсан. Ингэснээр цаашид багш нар хүүхдүүдийнхээ гэрээр айлчлан мэдээлэх оролцоо нь нэмэгдэнэ мөн тэдгээр 11 НА болон Сайхан сумын 14 багшийг урлагийн сэтгэл засал чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамруулж чадавхижуулсан.*

Томоохон хөрөнгө оруулалтын төсөв:

- *Хэрх ЕБ-ын сургуулийн гадаах хогийн сав – 6 000 000₮*
- *Мандал сумын шүүхийн хүүхэд хамгааллын өрөө – 2 863 438.25₮*
- *Мандал сумын хүүхдийн ордон паар – 3 000 000₮*
- *Мандал сумын ЕБ-ын 2р сургууль токарын сургалтын машин – 5 754 000₮ /захиалагдсан/*
- *3 суманд клубуудыг дэмжсэн төсөл – 11 530 000₮*
- *Мандал сумын нэгдсэн хогийн цэгийн хашаа – 19 025 000₮ / захиалагдсан/*
- *Баянгол сумын цэцэрлэгт 25 хүүхдийн ор – 2 875 000₮*
- *Баянгол сумын хамтарсан багт хүүхэд хамгааллын өрөө – 2 400 000₮*

Орон нутгийн оролцоо ба хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр

2022 оны хүрээнд хүүхдэд чиглэсэн нийт 5 чиглэлийн сургалт, чуулган, тусламж, дэмжлэг болон уулзалтуудыг зохион байгууллаа.

1. Зорилтот орон нутгуудын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ‘ I volunteer’ цахим сургалтыг зохион байгуулж нийт 50 суралцагч хамрагдсан бөгөөд үүнээс 12 эрэгтэй, 38 эмэгтэй суралцагч оролцлоо. Үүнээс нийт RC 7, эмэгтэй RC-5, эрэгтэй RC-2 байна.
2. Мандал сумын ерөнхий боловсролын сургуулиудын “Өсвөрийн сэтгүүлч” клубын гишүүдэд хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр, хүүхэд хяналтын талаар мэдлэг олгох танхимын сургалтыг зохион байгуулж нийт 16 сурагч хамрагдсан бөгөөд 2 эрэгтэй, 14 эмэгтэй сурагчид байна. Үүнээс RC-2 эмэгтэй байна.
3. Зорилтот орон нутгийн RC өрхүүдэд түлээ-4, хувцас-5, хүнсний тусламжийг-4 үзүүлсэн бөгөөд нийт 13 өрхөд дэмжлэг үзүүлсэн. Үүнээс нийт RC эрэгтэй 5, RC эмэгтэй 8 хамрагдлаа.
4. Хөтөлбөрт бүртгэлтэй зорилтот орон нутаг Мандал сум, Түнхэл тосгон, Сайхан сумын 9 хүүхдэд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж нийт RC эрэгтэй 3, RC эмэгтэй 6 хүүхэд хамрагдлаа.
5. Оролцооны клубын хүүхдүүдийн “үр дүнгийн” уулзалтыг зохион багйуулж нийт 20 хүүхэд хамрагдснаас нийт эрэгтэй- 5, эмэгтэй-15, RC эмэгтэй 5 байна.
6. Мандал суманд “хөгжлийн түүчээ” чуулга уулзалтыг оролцооны клубуудын гишүүдтэй хамтран зохион байгуулж нийт 245 хүүхэд хамрагдсан. Үүнээс нийт эрэгтэй 64, эмэгтэй 181, RC эрэгтэй-11, RC эмэгтэй-30 хамрагдлаа.
7. Мандал сумын өсвөр насны 467 хүүхдэд “Аюулгүй сонголт” сургалтыг зохион байгуулж нийт эрэгтэй 228, эмэгтэй-239, RC эрэгтэй-19, RC эмэгтэй-17 хамрагдлаа.
8. Зорилтот орон нутаг Мандал,Сайхан,Баянгол сумын 23 сайн дурын ажилчдад төрийн бус байгууллагын талаар мэдлэг ойлголт өгөх танхимын сургалтыг зохион байгуулсан.
9. Зорилтот орон нутаг Мандал, Сайхан, Баянгол сумын нийт 22 сайн дурын ажилчдад хүнсний тусламжийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд энэхүү тусаламжаар дамжуулан нийт RC 7 эрэгтэй, RC 15 эмэгтэй ашиг шим хүртсэн.
10. Мандал,Сайхан,Баянгол сумын ерөнхий боловсролын сургуулийн 100 эмэгтэй багш ажилчдад хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн хүүхэд хяналтын талаар мэдлэг олгох цахим сургалтыг зохион байгуулсан.
11. Мандал сумын 116 алба хаагчдад”стресс менежмент” сургалтыг зохион байгуулж нийт эрэгтэй 54, эмэгтэй 62 алба хаагч хамрагдлаа.

12. Зорилтот орон нутгийн иргэний нийгмийн байгууллага болон иргэдэд “төсөл хэрхэн бичих вэ” сургалтыг зохион байгуулж эрэгтэй 2, эмэгтэй 30 хүн хамрагдаж нийт 32 хүүхэд оролцлоо.
13. Зорилтот орон нутгийн 22 сайн дурын ажилтанг “сайн дурын ажилчдын өдөрлөг”-т хамруулсан.
14. Мандал сумын орон нутаг болон боловсролын багйууллагын удирдлагуудад өглөөний уулзалтыг зохион байгуулж нийт 8 эрэгтэй 23 эмэгтэй оролцлоо.

15. Мандал сумын 4 сүм чуулганатай хамтран зул сарын баярын үйл ажиллагааг зохион байгуулж нийт эмзэг бүлгийн 200 хүүхдийг хамруулсан. Мөн Хэрх тосгоны бүтэн өнчин 25 цэцэрлэгийн хүүхдэд зул сарын баяртай холбогдуулан дэмжлэг үзүүлсэн. Энэхүү үйл ажиллагаагаар нийт 225 хүүхдэд хүрч ажилласан бөгөөд үүнээс нийт эрэгтэй 103, эмэгтэй 122, RC 9 эрэгтэй, RC 10 эмэгтэй хамрагдсан. Зориолтот орон нутгийн 4 жижиг төслийг хэрэгжүүлэхээр үйл ажиллагааг эхэлсэн байгаа бөгөөд нийт хэрэгжүүлж буй төслүүдээр дамжуулан 700 иргэд хүүхдэд ашиг шим хүртэнэ.

16. Сайхан болон Баянгол сумын 30 хүүхдэд сэтгэлзүйн зөвөлгөө үйлчилгээг үзүүлсэн.

17. Мандал сумын ерөнхий боловсролын сургуулиудын 45 эрэгтэй суралцагчдад эко аялал сургалтыг зохион байгуулж нөхөрлөлийн талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.

Мандал суманд эсгий урлалын жижиг төслийн хэрэглэгдэхүүн ноос, цавуу, утас, гутлын хэв зэрэг хэрэгцээт бараа бүтээгдэхүүний дэмжлэг үзүүлж үйл ажиллагаагаа эхлүүлэн жижиг төслийг хэрэгжүүлж байна - 3500000₮

Мандал сумын 4-р сургуулийн залуу багш нарын холбооны хэрэгжүүлж буй жижиг төслийн хэрэглэгдэхүүн, ном, ховилтой дэвтэр, самбарын хэрэглэгдэхүүн, номын шүүгээ, тавиур, эвлүүлдэг тоглоомоор дэмжлэг үзүүлж үйл ажиллагаагаа эхлүүлэн жижиг төслийг хэрэгжүүлж байна – 3900000₮

Мандал сумын сүм чуулганы хэрэгжүүлж буй монтеessori арга зүйн хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүлж жижиг төслийг хэрэгжүүлж байна - 3200000₮

Сайхан суманд гар урлалын жижиг төслийн хэрэглэгдэхүүн бэлдэц, шүр, шигтгээт наамал, бичгийн хэрэгсэл, оёдолын болон хэрээсний машины дэмжлэг үзүүлж үйл ажиллагаагаа эхлүүлэн жижиг төслийг хэрэгжүүлж байна - 3200000₮

Өрхийн даван туулах чадвар ба амьжиргааг сайжруулах техникийн хөтөлбөр

- ТӨГСӨЛТИЙН АРГАЧЛАЛ
- ДУНДЫН ХАДГАЛАМЖИЙН БҮЛ
- БЭЛЭН БАЙ арга аргачлалуудаар дамжуулан төслийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

2022 оны санхүүгийн жилд зорилтот гурван орон нутаг болох Мандал, Баянгол, Сайхан сумдын ЗДТГ, төрийн болон ТББ-ууд, ОБА хэлтэс, хамтрагч байгууллагууд, орон нутгийн иргэлдтэй хамтран дараах төсөл хөтөлбөр үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Бага дунд орлоготой өрхийн амжиргааг дэмжих зорилготой Төгсөлтийн аргачлал хөтөлбөрт Мандал сумын 41 өрх хамрагдаж, хувь хүний хөгжил төлөвшил, харилцаа хандлага, хүүхэд хүмүүжил оролцоо, гэр бүлийн сургалт, дундын хуримтлалын бүлэг, бизнес санхүү, маркетингийн сургалт, төсөл бичих сургалт, бүлийн сургалт, гамшгийн сургалт, түршлага судлах аялал зэрэг цогц сургалт үйл ажиллагаагаар дамжуулан чадваржуулж, урт хугацааны амжиргаа сайжруулах төлөвлөгөөний дагуу тоног төхөөрөмж, эд материалын дэмжлэг үзүүлж, оролого нэмэгдүүлэхээс гадна төсөлд хамрагдаж буй өрхүүдийг тогтмол хянах, төрийн үйлчилгээнд хамруулах, холбон жуучлах, ажлыг хянан зөвлөхүүд, сайн дурын ажилтануудтайгаа хамтран тогтмол зохион байгуулж байна. Төслийн үр дүнд 140 хүүхэд, 76 насанд хүрэгчид үр шим хүртгэж, бизнесийн 6 бүлэг үүсч, 3 бүлэг ажлын байр нэмэгдүүлэн ажиллаж байна. Нийт өрхүүдийн 85% нь бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тогтвортойгоор амжиргаагаа нэмэгдүүлж байна.
2. Дундын хуримтлалын бүлийн аргачлалыг тогтвортойгоор үргэлжлүүлэх зорилгоор 16 сургагч багшийг орон нутагт бэлтгэн, удаа дараагийн чадваржуулах сургалтуудад хамруулсан.
3. Бага дунд орлоготой иргэдийг мөнгөн хуримлал үүсгэх дадал хэвшилд сургах, хуримтлуулсан хадгаламжаа зээл дэмжлэг авч хувийн бичил бизнес эрхлэх болон боловсрол, эрүүл мэнд зэрэг яаралтай үед хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүгийн чадварыг сайжруулах зорилгоор хэрэгжүүлсэн Дундын хадгаламжийн бүлэг аргачлалд 9 хуримтлалын бүлгийн 181 иргэн хамрагдаж, 38462150 төгрөгийн мөнгөн хуримтлал үүсгэсэн байна. Дундын хуримтлалын бүлэг нь орон нутагт танигдсан амжилттай хэрэгжиж буй аргачлал бөгөөд Бизнесийн бүлэг, худалдаачдын бүлэг, байгууллага хамт олны бүлэг, малчдын бүлэг, уурхайчдын бүлэг, анги хамт олны бүлэг, гэр бүл хамаатнуудын бүлэг, найзуудын бүлэг гэх зэргээр өргөжин нийгмийн сангийн хуримтлалаар спорт урлагийн уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулж, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэн сайн үйлсийн аян өрнүүлэх, хандив тусламж үзүүлэх зэрэг үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна.
4. Өрхийн даван түүлах чадварийг сайжруулах зорилгоор орон нутгийн онцгой байдлын алба хэлтэстэй хамтран Бэлэн бай хөтөлбөрийг хэрэгжүүлэн, орон нутагт сургагдсан багш нараар дамжуулан иргэд, хүүхдүүдэд чиглэсэн чадваржуулах сургалт үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсан ажиллаж, 2022 оны санхүүгийн жилд зорилтот орон нутгийн 6000 гаруй иргэд хүүхдүүдэд хүрсэн байна. Гамшиг эрсдэл тохиолдсон үед яаралтай хариу үйлдэл үзүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч шаардлагатай, дэмжлэгүүдийг үзүүлж ажилладаг. Энэ хүрээнд Онцгой байдлын алба хэлтэсүүдэд сургалтын өрөө тохижуулж, хэрэгцээтэй тоног төхөөрөмжийн дэмжлэгийг үзүүлэн хамтран ажиллаж ирсэн. ЕБС-н сургуулиудад шинээр 5 Өсвөрийн аврагч клубүүдийг нээж, 97 клубын гишүүдийг чадваржуулан сургуулийн орчинд үе тэнгийнхэндээ нөлөөлөх, гамшиг осолын талаар мэдлэг мэдээлэл өгөх, сургалт үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.
5. Хувь хүний хөгжил, харилцаа хандлагын сургалтыг зорилтот 3 орон нутгийн 2180 иргэдэд зохион байгуулсан.
6. Бизнес санхүү, маркетинг, төсөл бичих сургалт, бүлийн сургалт зэрэг чадваржуулах сургалтанд өрхийн бичил бизнес эрхлэгч иргэд болон бүлийн бизнес эрхэлдэг 157 иргэдийг хамруулсан.

7. Зүүнхараа Политехникийн коллежтэй хамтран богино хугацааны мэргэшүүлэх сургалтыг амжиргааны баталгаажих төвшинээс доогуур орлоготой өрхийн гишүүдэд оёдолчин, үсчин, гагнуур, ойжуулалт мэргэжлүүдээр 83 хүнийг мэргэжлийн үнэмлэхтэй сургалтанд хамруулсан байна.

Томоохон хөрөнгө оруулалтууд, төсөв:

- Өрхөд чиглэсэн амжирагаа дэмжих жижиг төслүүд – 37 863 703₮
- Бүлийн бизнес хөгжлийг дэмжих төсөлд тоног төхөөрөмж, эд материалын дэмжлэг – 16 162 594₮
- Мандал сумын Баянсуудлын 3-р багт- Багийн дэргэдэх бизнес хөгжлийн төвийг тохижуулах – 19 071 736₮
- Мандал сумын Онцгой байдлын хэлтэст “Аврагч Мазаалай” сургалтын өрөөг тохижуулах – 20 593 936₮ /захиалагдсан/
- Мандал сумын Онцгой байдлын хэлтэст ойн хээрийн түймэрийн үед хэрэглэгдэх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл – 5 850 109₮
- Өсвөрийн аврагч клубуудын хувцас хэрэглэгдэхүүн – 6 875 250₮
- Сургуулиудын эрсдлийн үнэлэгээнд хариу үйлдэл үзүүлэх зорилгоор Баянгол сумын сургуульд гадна дотор орчны ангилдаг хогийн савууд, Номгон тосгоны ЕБС-д гарцын тэмдэг тэмлэглэгээ – 10 250 000₮
- Богино хугацааны мэргэшүүлэх сургалтын төлбөр – 21 193 500₮
- Орон гэргүй нэн хүнд нөхцөлд байгаа 4 өрхөд гэрээр дэмжлэг үзүүлсэн – 19 800 000₮
- Хувь хүний хөгжил, сэтгэлгээ хандлага, бизнес, өрхийн санхүү, маркетинг, бүлийн хөгжил, гамшгийн эрсдэлийг бууруулах зэрэг чадваржуулах сургалтууд, сургалтын хэрэглэгдэхүүнд – 22 602 749₮